

ёсны төлөөлөгч болон эрх бүхий байгууллага, хэрэв шаардагдвал хуухдийн өөрий нь эөвшөөрлийг гаргуулвал зохино^

3, Хуухэд урчлэн авагчдын нэг нь Хэлэлцэн Тохирогч нэг Этгээдийн харьяат нөгөө нь Хэлэлцэн Тохирогч нөгөө Этгээдийн харьяат бол хуухэд урчлэн ^{авах} буюу туунийг хучингуй болгох явдлыг Хэлэлцэн Тохирогч хоёр Этгээдийн нутаг дэвсгэрт дагаж журамлан байгаа хууль тогтоомжийн дагуу гуйцэтгэнэ.

Гучин наймдугаар зүйл

Урчлэн авах буюу туунийг хучингуй болгох явдлыг хуухэд урчлэх, туунийг хучингуй болгох уед урчлэн авагчийг харьяалж байсан Хэлэлцэн Тохирогч Этгээдийн байгууллага шийдвэрлэх эрхтэй байна. 37 дугаар зүйлийн 3 дахь ангид заасан тохиолдолд гэрлэгсдийн суулчийн удаа хамт оршин сууж байсан буюу байгаа газрын эрх бүхий байгууллага шийдвэрлэх эрхтэй»

3. Асран хамгаалах» харгалзан

дэмжих

Гучин есдугээр зүйл

1. Асран хамгаалах, харгалзан дэмжих асуудлыг тогтоох буюу хучингуй болгохдоо асран хамгаалуулагч ба харгалзан дэмжуулэгчийг / цаашид асруулагч гэж нэрлэгдэх / харьяалах Хэлэлцэн Тохирогч Этгээдийн хуулийг баримтална.

2. Асран хамгаалагч, харгалзан дэмжигч болон асруулагчдын хоорондын эрхийн харилцааг асран хамгаалагч, харгалзан дэмжигчийг томилсон байгууллагыг харьяалах Хэлэлцэн Тохирогч Этгээдийн хуулиар тогтооно.

3. Асран хамгаалах, харгалзан дэмжих уургийн талаар асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн байгаа Хэлэлцэн Тохирогч Этгээдийн хуулийг баримтална»